

## ЗӨВЛӨГӨӨН, СПОРТЫН АРГА ХЭМЖЭЭНД ОРОЛЦЛОО

Биеийн тамир, спортын тухай хууль, Монгол Улсын Еерхийлөгчийн санаачилсан “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөн, Олимп нийтийн биеийн тамирын үндэсний хорооноос дэвшүүлсэн зорилго зорилт, Биеийн тамир, спортын салбарт зохистой түншлэл, салбар хооронддын уялдаа холбоог хангах удирдлагын оновчтой тогтолцоог сайжруулах, ажилтан албан хаагчдын хамтын ажиллагааг бэхжүүлэх, туршлага солилцох зорилгоор Биеийн тамир, спортын салбарын албан хаагчдын дунд зохион байгуулагдах зөвлөгөөн, спортын арга хэмжээнд 2023 оны 08 дугаар сарын 01-05-ны өдрүүдэд Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын ажилтан, албан хаагчид бүрэн бүрэлдэхүүнээрээ оролцлоо.




Зөвлөгөөн, спортын арга хэмжээний нээлтийн арга хэмжээг 2023 оны 08 дугаар сарын 02-ны өдөр Хэнтий аймгийн Чингис хотод зохион байгуулж Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын дарга Ж.Ганболд оролцсон.

Арга хэмжээнд нийт Биеийн тамир, спортын Улсын хороо, Нийслэлийн Биеийн тамир, спортын газар, 9 дүүргийн Биеийн тамир, спортын хороод, 21 аймгийн Биеийн тамир, спортын газрын нийт 32 байгууллагын 250 ажилтан, албан хаагчид оролцлоо.



Спортын арга хэмжээг 100 буудалт даам, Волейбол, дартс, олс таталт, Ширээний теннис, шугаман бүжиг, Урлагийн тэмцээн гэсэн уралдаан тэмцээн, арга хэмжээ зохион байгуулагдсан.



Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын албан хаагчид 2023 оны 08 дугаар сарын 01-05-ны өдрүүдэд Хэнтий аймгийн Чингис хотод зохион байгуулсан зөвлөгөөн болон спортын арга хэмжээнд бүрэн бүрэлдэхүүнээрээ оролцоод ирсэн.